



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.3, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын драмын эрдмийн театрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлаж ашиглах боломжгүй болсон 8,000,000.00 (найман сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Улсын драмын эрдмийн театрийн захирал Д.Цэрэнсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу Ажлын хэсэг байгуулан зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2 дугаар улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягтын хамт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА




З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000075

Улсын драмын эрдмийн театрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашинны жагсаалт

Төрийн өмчийн боллого, зохицуулалтын газрын
 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн
 ...№... дугаар тогтоолын хавсралт



Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	ТӨБЭЗГ-ын 2019 оны 191 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ	Худалдах доод үнийн санал
				8,000,000	8,000,000				
1	Леганз, УНУ 19-70, суудлын, арал: КЛАУА698ДХВ256082	1999/2006	121,868	8,000,000	8,000,000	-	-	1,500,000.00	750,000.00
Нийт дүн				8,000,000	8,000,000	-	-	1,500,000.00	750,000.00

/төгрөг/

(найман сая)

(нэг сая таван зун мянган)

(долгон зун тавин мянган)